

ҮЗЭЛ СУРТАЛ

**ХЯТАДЫН КОММУНИСТ НАМЫН
60 ЖИЛИЙН ОЙД**

Б. Батболд
Түүхийн ухааны дэд
эрдэмтэн

1921 оны 7-р сарын 1-нд Шанхай хотноо коммунист хэд хэдэн дугуйлан нийлэн нэгдэж Хятадын коммунист нам (ХКН)-ыг байгуулснаас хойш 60 жил өнгөрлөө.

Өнгөрсөн хугацаанд ХКН хүнд бөгөөд ярвигтай замыг туулж ирэв. ХКН-ын туулсан түүхэн замнал нь зөвхөн энэ намын төдийгүй дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөнд анхаарууштай сургамжтай зүйл болсныг өнөөгийн хятад дахь үйл явдал гэрчилж байна.

Юуны түрүүнд ХКН-ын үүсэж хөгжсөн өвөрмөц нөхцөл нь энэ намын дотор эхнээсээ марксч-ленинч, интернационалч болон жижиг хөрөнгөтөн, үндсэрхэгч хоёр чиг шугам бүхий хүчин өрсөлдсөөр ирсэн онцлогтой болохыг харууллаа. Хятадын ард түмний тэмцлийг ялалтанд хүргэн, социализмын замд оруулсан явдал бол ХКН, хятадын коммунистууд нь марксизм-ленинизмын аугаа их сургаалыг удирдлага болгон, ард түмний хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэн империалистүүд болон жижиг хөрөнгөтөн, феодал газрын эздийн эсрэг эвлэршгүй тэмцэл явуулсны үр дүн болсон юм. Хятадын хувьсгалын ялалт бол үнэндээ хятад дахь марксизм-ленинизмын хүчний ялалт байсан билээ.

Чухамхүү Хятад оронд коммунист нам байгуулагдсан явдал бол нэн тэргүүнээ аугаа их Октябрийн социалист хувьсгалын нөлөөн дор Дорно дахины дарлагдсан ард түмэн, түүний дотор хятад дахь үндэсний эрх чөлөөний болон хувьсгалт ардчилсан хөдөлгөөн идэвхжиж, хятадын шинэ тулгар ажилчин ангийн улс төрийн идэвхжил өссөнтэй шууд холбоотой юм.

ХКН анхдугаар их хурлынхаа баримт бичигт «намын гол зорилт нь хятад оронд пролетарийн диктатурыг тогтоон социализмыг байгуулж коммунизмын төлөө тэмцэн коммунист интернационалтай хамтран ажиллана» гэж заажээ. Тэгээд ч Коминтерн, юуны түрүүнд ЗХУКН-тай ажил хэрэгч холбоо тогтоон хятадын ард түмнээс үндэсний болон нийгмийн чөлөөлөлтийн төлөө явуулж байсан тэмцлийг удирдах болсон юм.

ХКН-ыг үндэслэгчдийн нэг, коммунист интернационалч Ли Дажао хятадад үзүүлсэн Октябрийн хувьсгалын ач холбогдлын талаар бичихдээ: «Дэлхийн шинэ соёл иргэншлийн туяа гэж оросын хувьсгалаар бид бахархан баярлаж байх ёстой. Эрх чөлөө, энэрэнгүй зарчимд тулгуурласан шинэ Орос улсаас ирэх мэдээ бүрийг бид анхааралтай сонсох хэрэгтэй байна. Зөвхөн тийм үед л бид дэлхийн дэвшил хөгжилтэй хамт алхаж чадах болно»¹ гэжээ.

Хятадад нийгмийн чөлөөлөлтийн төлөө өрнөсөн хөдөлмөрчдийн тэмцэл империализмын эсрэг тэмцэлтэй нягтаар хослон явагдсан юм. Хя-

¹«Опасный курс», вып. II. М., 1971, 49-р тал.

тад орныг хагас колони болгосон империализм нь тэр үед хувьсгалын өрнөлтөд ноцтой садаа болж байв. ХКН-ын удирдлага дор явагдсан чөлөөлөх хөдөлгөөн нь капиталистууд бол «олон улсын чанартай хүч мөн» гэсэн Лениний дүгнэлтийн үнэн зөвийг харуулж, тэгээд ч Лениний сургаснаар түүнийг ялан дийлэхэд зөвхөн «олон улсын ажилчин ангийн холбоо, тэдний ах дүүсэг байдал хэрэгтэй»² гэдгийг яруу тодоор нотлон баталсан билээ.

Хятадын коммунист нам, хятадын хөдөлмөрчин олны хувьд тийм найдвартай түшиж тулах холбоотон нь ЗХУКН, зөвлөлтийн ард түмэн, дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөн болсон юм. Коминтерн болон зөвлөлтийн коммунистууд хятадын хувьсгалч нарт империализмыг эсэргүүцсэн 1919 оны 5-р сарын 4-ний хөдөлгөөний» дараа тэднийг марксист-ленинист үзэл санааны үндсэн дээр нэгтгэн анхны марксист бүлгэм, дугуйлан байгуулах зэрэгт нь зайлшгүй хэрэгцээтэй асар их тусламжийг үзүүлсэн билээ.

Үндэсний ардчилсан хувьсгалын гал дөлөн дунд Хятадын Коммунист нам үүсэж хөгжсөн бөгөөд империализм, феодализмын эсрэг программыг дэвшүүлэн тавьж байв. Гэвч ХКН-ын I-III их хурлын хоорондох үе буюу 1924 он хүртэл ХКН нь зохион байгуулалт, үзэл суртлын талаар эмхрэн цэгцэрч байсан бөгөөд 1922 онд Коминтернд элсэн оржээ. 1923 онд болсон ХКН-ын III их хурал дээр хувьсгалч, ардчилсан үзэлтэн Сунь Ятсений удирдаж байсан гоминьданы намтай үндэсний хувьсгалт фронтыг нэгтгэх бодлого дэвшүүлжээ.

Хятадад тэр үед империализмыг эсэргүүцсэн өргөн олны хөдөлгөөн өрнөж байсан бөгөөд ажилчин анги гол хөдөлгөх хүч нь болж байв. Тийм ч учраас үндэсний хувьсгалд пролетаруудын манлайлах үүргийг бататгах явдал ХКН-д чухлаар шаардагдаж байв. Гонконг-Кантоны далайчид болон Шанхайн ажилчдын нийтийн ажил хаялт, бүх орон даяар идэвхжсэн тариачдын хөдөлгөөний өсөлт зэрэг нь ажилчин анги бол хувьсгалын манлай бөгөөд намын түшиж тулах гол хүчин, тариачид бол ажилчин ангийн гол холбоотон бөгөөд тэдний тусламж дэмжлэггүйгээр хятадад хувьсгал ялж чадахгүйг тодорхой харуулсан билээ. Гэвч 1927 онд Чан Кайши толгойлсон гоминьданы баруун жигүүр хувьсгалын эсрэг эргэлт хийж нэгдмэл фронтыг уналтад хүргэсэн юм. Хятад орон даяар ХКН-ын гишүүд болон түүнд талтай дэмжин талархдаг хүмүүсийг баривчлан залхаан цээрлүүлэн харгислаж эхэлжээ. Тэдний дунд ХКН-ын нэрт зүтгэлтнүүд, тухайлбал, Сян Жунфа, Цюй Цюбо, Жан Тайлай нарын зэрэг коммунистуудын амь насыг бүрэлгэжээ. Энэ үед ХКН-ын дотор баруунтны хэлбэр нэлээд газар авч намыг өргөн олноос холдуулах дэлхийн коммунист хөдөлгөөний туршлага сургамжийг авах явдалд, тухайлбал Коминтерний зөвлөмжийг үл хэрэгсэх байдал илэрсэн нь намыг улам хүнд байдалд оруулжээ. Чан Кайшигийн харгис этгээдүүд ХКН-ын эсрэг харгислалаа зөвлөлтийн эсрэг явуулагатай зэрэгцүүлэн явуулж, тэр ч байтугай зөвлөлтийн эсрэг элдэв гүжир гүтгэлгийн кампани дэгдээж, дайтахыг уриалж байв.

ХКН-д тохиолдсон ийм хүнд нөхцөлд ЗХУКН болон зөвлөлтийн коммунистууд хятадын эх орончдыг хамгаалахын төлөө олон улсын хөдөлгөөн өрнүүлэх санаачлагыг дэвшүүлсэн юм. Коминтернээс дэлхийн бүх коммунистуудад хандаж «хятадын хувьсгалыг бүхий л талаар дэмжихийг» уриалсан уриалга гаргажээ. Энэ үед дэлхийн коммунист хөдөлгөөний дайчин отрядын нэг МАХН хөрш хятад оронд болж буй хувьс-

галт хөдөлгөөнийг бүхий л талаар дэмжин ХКН-ыг байгуулагдсан цаг үеэс эхлэн хятадын хувьсгалт нэгдмэл фронттой ажил хэргийн холбоо тогтоон, эд материалын болон сэтгэл санааны бодитой дэмжлэгийг үзүүлэн, эв санааны дайчин нэгдлээ илэрхийлж байсан юм. 30-аад оны эхнээс ХКН-ын байдал дахин эрс хүндэрсэн юм. Энэ үед хятадын харгис хүчин Коммунист намын гишүүдийг элдвээр залхаан цээрлүүлж харгислалаа улам нэмэн үргэлжлүүлсний гадна, намын эгнээнд жижиг хөрөнгөтний элдэв элементүүд шургалан орж 30-аад оны дундаас эхлэн намын удирдах гол тушаалуудыг эзлэн авсан юм. Нэн ялангуяа ХКН дахь жижиг хөрөнгөтөн, үндсэрхэх үзэлтний гол төлөөлөгч болж байсан Мао Зэдун ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны ихэнхи гишүүдийг байхгүй үеэр 1933 оны 1-р сард Зуны-д болсон ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны өргөтгөсөн хурал гэгч дээр нам, армийн удирдлагыг гартаа авсан юм.

Мао Зэдун болон түүний талынхан улмаар ХКН-ын дотор цэвэрлэх хөдөлгөөн гэдэг нэрийн дор хятадын интернационалч хүчин рүү дайралт хийж, элдвээр хорлон бусниулж, марксизм-ленинизмийг «Мао Зедуны үзэл санаагаар» орлуулах хорт явууллагаа хийж эхэлсэн юм.

Гэвч хятадын жинхэнэ коммунистууд, интернационалч хүчин нь энэ хүнд бэрх нөхцлийн дунд ард түмний хувьсгалт тэмцлийг удирдсаар байсан билээ.

Японы империализм хятадын эсрэг түрэмгийлэл үйлдсэнтэй холбогдуулан ХКН ард түмнийхээ санаа сэтгэлийг илэрхийлэн японы түрэмгийлэгчдийн эсрэг нэгдсэн фронт байгуулах санаачлага гаргаж, энэ тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэсэн учир улс төрийн ихээхэн нөлөө бүхий хүч болон өссөн билээ. Японы эсрэг дайн нь хүнд нөхцөлд удаан үргэлжилсэн юм. Гагцхүү гитлерийн фашизм, японы милитаризмыг зөвлөлтийн улаан арми бут цохисны үр дүнд хятадыг японы булаан эзлэгчдээс чөлөөлсөн билээ. Нэн ялангуяа зөвлөлт, монголын дайчид Алс Дорнодод Квантуны шилмэл армийг буулгаж Манжуурыг чөлөөлсөн явдал үлэмж ач холбогдолтой болж улмаар Чан Кайшигийнхэнд цохилт өгөх урьдчилсан нөхцлийг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн зөвлөлтийн улаан арми болон зөвлөлтийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар хятадын коммунистуудаас Манжуурт байгуулсан цэргийн хувьсгалт бааз хятадын хувьсгалын ялалтанд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Чухамхүү энэ баазад цэргийн эрдэмд суралцан, шинээр зохион байгуулагдсан хятадын Ардын чөлөөлөх арми ХКН-ын удирдлага дор гоминьданы харгисуудыг хятадаас үлдэн хөөж зайлуулсан билээ.

Империализм, феодализмыг эсэргүүцсэн хятадын ардчилсан хувьсгалын ялалт нь дэлхий дахины ач холбогдолтой үйл явдал болсон юм. Үнэн хэрэгтээ хятадын хувьсгалчдаас олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнтэй тогтоосон ойр дотнын харилцаа, олон улсын эв санааны нэгдэл, Зөвлөлт Холбоот Улс болон социалист системийн орнуудын сэтгэл харамгүй тусламж нь хятадын ард түмэн, ажилчин, тариачин, сэхээтэн нараас ХКН-ын удирдлагын дор олон арван жилийн турш амь бие хайрлахгүй явуулсан хүнд бэрх тэмцлийг ялалтанд хүргэх бололцоог хангасныг тэмдэглэх хэрэгтэй юм.

Хятадын хувьсгалын ялалт нь тус орны олон зуун сая ард түмэнд улс төр, нийгэм эдийн засгийн салбарт гүн гүнзгий үндсэн өөрчлөлт хийх бололцоог олгосон билээ. Хятадын хувьсгалын цаашдын хөгжилт, социализмын замд орсон явдал болон империализмын зүгээс учруулж болох түрэмгийллийн аюул занал нь хятад улсаас Зөвлөлт Холбоот Улс болон социализмын орнуудтай хамгийн ойр дотнын харилцаа, хамтын ажиллагаа тогтоохыг шаардаж байлаа. Зөвхөн эдгээр орнууд л БНХАУ-д

хэрэгцээт улс төр, цэрэг, эдийн засгийн тусламжийг үзүүлж чадах байв. Пролетарийн болон социалист интернационализмын зарчимд үнэнч ЗХУ-ын Коммунист Нам, Зөвлөлт засгийн газар нь хятадын ард түмэнд шинэ амьдралыг цогцлон байгуулах их үйлсэд сэтгэл харамгүй чин сэтгэлийн тусламж үзүүлж, ЗХУ-ын техник, мэргэжилтний туслалцаатайгаар БНХАУ-д 250 гаруй орчин үеийн үйлдвэр, заводууд барьж өгсөн юм. Энэ нь ХКН-ын удирдлагын хүлээн зөвшөөрснөөр «хятадын аж үйлдвэрийн үндэс болсон» билээ.

Ийнхүү Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсаны дараах эхний 10 жилд тус оронд социализмын өрнүүн байгуулалт үргэлжлүүлж болох эдийн засгийн нөөц бааз бий болсон юм. 1956 онд хуралдсан ХКН-ын VIII их хурал ХКН, ард түмний түүхэнд онцгой ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд намын доторхи марксист-ленинист хүчний бэхжилтийг харуулсан билээ. Тэгээд ч уг хурлаас БНХАУ-д социалист системийн орнуудын нягт хамтын ажиллагаанд тулгуурлан социализмыг амжилттай байгуулах тухай намын жанжин шугамыг баталсан юм. Энэ үед ХКН дахь их гүрний үндсэрхэг үзэл бүхий хүчин жинхэнэ нүүр царайгаа нууж, тухайн үед хүчээр дутмаг гэдгээ ойлгон тус их хурлын шийдвэрийг арга буюу баталсан боловч удалгүй Мао Зэдуны болон түүний талынхан цаашдаа VIII их хурлын шийдвэрийг биелүүлэхээс татгалзан түүнийг няцаахад чиглэсэн балмад ажил явууллагыг өргөн хүрээтэй явуулсан юм. Тэд юуны түрүүнд намын дотор намын эсрэг, ажилчин ангийн эсрэг жижиг хөрөнгөтний үзэл үржих бололцоог нээсэн байлаа.

Ийнхүү ХКН-ын удирдлагад жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэл бүхий Маогийн бүлэг давамгайлах болсны уршгаар дэлхийн коммунист хөдөлгөөний томоохон отрядын нэг болж байсан ХКН нь хятадын ажилчин ангийг жолоодон манлайлах ролио алдаж, гунигт алдаанд хүрснийг хятадын нийгэм-эдийн засгийн өнөөгийн хөгжлийн гашуун туршлага гэрчилж байна. Тиймээс ч тэд социализмыг аль болох хурдан байгуулах гэсэн хятадын ард түмний жинхэнэ хүсэл эрмэлзлийг өөрсдийн явцуу сонирхолдоо ашиглан хэт зүүний лоозонгоор халхавчлан «их үсрэлт», «соёлын хувьсгал» зэргийг зохион байгуулжээ. Энэ нь ХКН, төрийн дээд удирдлагаас социализмын зарчмыг болон түүний мөн чанарыг мушгин гуйвуулсны хатуу сургамж болсон билээ.

ЗХУКН-ын XXVI их хурлын тайлан илтгэлд «соёлын хувьсгал» гэгчийн үед тус оронд (хятадад) бий болсон дэг журмыг «феодал-фашист хатуу диктатур» гэж хятадын өнөөгийн удирдагчид өөрсдөө нэрлэж байна. Ийм үнэлэлтэд нэмж хэлэх зүйл бидэнд алга»³ гэж тэмдэглэсэн юм.

ХКН нь марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмаас ухарч няцсан нь хятад улсыг гүн хямралд оруулсан бөгөөд хятадын ард түмний язгуур эрх ашигт харшилж байгаа хэрэг мөн. ХКН нь ийнхүү дэлхийн коммунист хөдөлгөөн болон дэвшилт хүчнээс хэлхээ холбоогоо таслахад хүрч байгаа явдал манай гаригийн бүх коммунистууд дэвшилт үзэлтэй бүхний сэтгэл санааг зүй ёсоор түгшээж байна.

Өнөөгийн байдлаар ХКН 39 сая орчим гишүүнтэй боловч 20-иод сая орчим нь албан хаагчид байна. Ажилчин анги ХКН-д хамгийн бага хэсгийг эзэлж дийлэнх олонхи нь тариачид хэвээр байна. ХКН-ын удирдлагаас зарласан намыг «цэгцлэх», «цэвэрлэх» ажил үргэлжилсээр байгаа бөгөөд энэ нэрийдлээр юуны түрүүнд намын доторхи зарим эрүүл саруул хүчин рүү байнга дайралт хийсээр байна. ХКН-ын удирдагч-

³Материалы XXVI съезда КПСС. М., 1981. 10 дугаар тал.

дын хүлээн зөвшөөрч байгаагаар намын нэр хүнд өргөн олны дунд ихээхэн буурсан бөгөөд намын ажлын арга барил нь засаг захиргааны аргаар буюу дур зоргоороо загнах явдал болжээ.

ХКН төрийн дээд удирдлага дотоод гадаад бодлогын үндсээ их гүрний дээрэнгүй, жанжлах үзэл дээр тулгуурлан явуулж байгаа бөгөөд сүүлийн үед дэлхийн империализм болон хамгийн харгис хүчинтэй эвсэн сүлбэлдэж, олон улсын байдлыг хурцатгах, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай сөргөлдөх, ердийн болон цөмийн зэвсгээр улайран хөөцөлдөх зэрэг аюултай чиг бодлогыг олон улсын тайзнаа баримталж байна.

Нэн ялангуяа хятад-америкийн ойртолт, цэргийн талын хамтын ажиллагаа өргөжиж байгаа явдал дэлхий нийтийн энх тайван, улс түмний аюулгүй байдалд үлэмж аюул занал учруулж байгаа хэрэг мөн. ЗХУКН-ын XXVI их хурлын тайлан илтгэлд тэмдэглэсэнчлэн хятадын өнөөгийн удирдлага дэлхийн бүх харгис хүчинтэй ийнхүү хуйвалдан сүлбэлдэж байгаа явдал «Хятадын хөгжлийг эрүүл саруул зам дээр эргүүлж гаргахгүй»⁴ нь мэдээж билээ.

Сүүлийн үед Хятадад болж байгаа нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралд нөлөөлсөн томоохон үйл явдал, нэн ялангуяа 1981 оны зургадугаар сарын сүүлчээр хуралдсан ХКН-ын Төв Хорооны VI бүгд хурлын материал, тухайлбал тус хурлаас баталсан «БНХАУ байгуулагдсанаас, хойших ХКН-ын түүхийн асуудлын тухай тогтоолыг» авч үзвэл хятад дахь нам, төрийн дээд удирдлагын төлөө бүлэглэлүүдийн тэмцэл үргэлжилсээр байгаа бөгөөд маоистуудын балмад номлол нь хятадын нийгмийн зөрчлийг улам гүнзгийрүүлж байна.

Хятадын өнөөгийн удирдлага марксизм-ленинизмд харш маоизмыг бүхий л талаар сэргээн шинэчлэн «намын удирдах үзэл санаа» болгон хэвээр үлдээхийг хичээж байна. Энэ нь хятад дахь социалист байгуулалт болон хятадын ард түмний жинхэнэ язгуур эрх ашигт эрс харшилж байгаа хэрэг мөн.

Энэ онд хуралдсан ЗХУКН-ын XXVI, МАХН-ын XVIII их хурал болон ах дүү бусад намуудын их хурлаас ХКН, хятад дахь нийгэм-эдийн засгийн байдалд өгсөн намч, ангич, зарчмын дүгнэлт хичнээн үнэн зөв болохыг өнөөгийн хятад дахь үйл явдал тов тодорхой харуулж байна.

ХКН-ын 60 жилийн замнал нь коммунистууд хувьсгалчид зөвхөн марксизм-ленинизмээр зэвсэглэсэн цагт л нийгмийн хөгжлийн зүй тогтол, хандлагыг зөв тодорхойлж социализм-коммунизмын төлөө тэмцлийн стратеги, тактикийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж чадахыг харуулж байна. Харин энэ зарчмаас ухрана гэдэг бол коммунист хөдөлгөөний тухайн отряд төдийгүй бүх коммунистуудын нийт үйл хэрэгт хохирол учруулна гэдгийг бас нотолж байна. Өнөөгийн БНХАУ дахь гүнзгий хямрал нь ХКН-ын удирдлага марксизм-ленинизмаас ухарч, их гүрний дээрэнгүй үзэлд автан, империализм болон дэлхийн харгис хүчинтэй сүлбэлдсэний уршиг боллоо.

«Хятадын эрх баригчид хамгийн харгис хүч, юуны өмнө америкийн империализмтай «стратегийн харилцан ажиллагаа», цэрэг-улс төрийн хамтын ажиллагааг бүх талаар идэвхжүүлэн социалист орнууд болон үндэсний эрх чөлөө, нийгмийн дэвшлийн хүчний эсрэг дайсагналал, сөргөлдөөнөө лавшруулж байна»⁵ гэж МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр н. Ю. Цэдэнбал онцлон тэмдэглэсэн юм.

ХКН нь их гүрний дээрэнгүй үзлийг таягдан хаяж хятадын ажилчин ангийг манлайлан жолоодох үүргээ сэргээн, марксизм-ленинизмийн

⁴Материалы XXVI съезда КПСС. М., 1981. 11 дугаар тал

⁵«Үнэн», 1981. II. 3,

үндсэн дээр олон улсын коммунист хөдөлгөөн болон империализмыг эсэргүүцсэн ардчилсан хүчинтэй ойр дотны харилцаа, хамтын ажиллагаа тогтоосон цагт өнөөгийн хүнд байдлаас гарч болох нь дамжиггүй юм.

ХКН, хятадын олон зуун сая хөдөлмөрчин олон эцсийн эцэст өнөөгийн нийгэм-улс төрийн хямралыг гэтлэн давж, социалист байгуулалтын замдаа эргэн орно гэдэгт бүх дэлхийн коммунистууд, дэвшилт хүчин найдвар төгс байна.

К 60-ЛЕТИЮ КОМПАРТИИ КИТАЯ

(Резюме)

Б. Батболд

Прошло 60 лет после того, как на 1 съезде КПК, состоявшемся в г. Шанхае 1 июля 1921 года, была образована Коммунистическая партия Китая. Образование КПК непосредственно связано с влиянием Октябрьской социалистической революции, а также расширением национально-освободительного и революционно-демократического движения в Китае. С тех пор КПК прошла трудный и сложный путь с победами и неудачами.

В начале 30-х годов положение в КПК резко осложняется. В это время не только реакционные силы продолжали усиливать репрессию против членов Компартии, но и мелкобуржуазные элементы, проникнув в ряды партии, заняли в ней главные позиции. Мао и его сторонники после захвата руководства в партии в январе 1935 года начинают проводить в партии многочисленные кампании чистки, травлю интернационалистических сил, подмену марксизма-ленинизма «идеями Мао Цзэ-дуна»

Несмотря на это, революционная борьба китайского народа, коммунистов-интернационалистов, интернациональная помощь содействовали тому, что партия оставалась в руководстве революционной борьбы и привела к победе китайской демократической революции, которая явилась в мировом революционном движении большим событием.

VIII съезд КПК, состоявшийся в 1956 году, сыграл большую роль в истории китайского народа. Съезд утвердил генеральную линию партии на построение социализма в КНР на основе тесного сотрудничества со странами социализма.

Мелкобуржуазные националистические силы в КПК вынуждены были признать решение съезда. Но вскоре Мао Цзэдун и его сторонники отказались от выполнения решений VIII съезда и начали проводить авантюристическую, антинародную политику, которая в конце концов привела страну в состояние хаоса.

Последние события в Китае, в частности «Решение по некоторым вопросам истории КПК со времени образования КНР», принятое на VI Пленуме ЦК КПК, говорят о том, что маоизм по-прежнему определяет основные направления внутренней и внешней политики нынешнего китайского руководства.

Пекинские лидеры делают все для того, чтобы «спасти маоизм», закрепить его в качестве партийной и государственной идеологии.

60-летний путь КПК показывает, что только вооружившись учением марксизма-ленинизма, коммунисты и революционеры смогут правильно определить закономерность и тенденцию общественного развития, создать на научной основе стратегию и тактику борьбы за социализм и коммунизм. Отход же от данного принципа приводит к трагическим последствиям, которые ныне характерны для КПК.

Только в том случае, если китайское руководство откажется от своей политики гегемонизма и великодержавного шовинизма, установит тесные отношения и сотрудничество с мировым коммунистическим движением, антиимпериалистическими, демократическими силами и на основе принципов марксизма-ленинизма, КПК сможет восстановить свою роль как авангард китайского рабочего класса и выведет Китай из состояния тяжёлого кризиса.